



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 4/19

Өмнөдэлгэр сум

Баримт нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, комиссын ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 24 дүгээр зүйлийн 24.1.7, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 25.3 дахь заалт, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.8, 2.9, 2.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Архивын баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, хадгалах хугацааг тодорхойлох, байнгын хадгалалтад баримт сонгох болон шилжүүлэхэд бэлтгэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий баримт нягтлан шалгах комисс (БНШК)-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга	А.Хэрлэнтунгалаг	ОНСТ-ын ажилтан
Нарийн бичгийн дарга	Н.Ганганмөрөн	бүжгийн багш
Гишүүн	С.Очир	хөгжмийн багш

2. Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааны дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын архивын баримт нягтлан шалгах комиссын дүрмийг нийт ажилтнуудад танилцуулж, комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг комиссын дарга (А.Хэрлэнтунгалаг)-т даалгасугай.

ДАРГА



Т.МӨНХТӨР